



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ДОА-2023/49/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.25 № 49

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2022 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 22 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 82.8 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020262

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балаасын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	165,679,733.43	165,288,848.93
35	БАРАА МАТЕРИАЛ	158,479,733.43	165,288,848.93
351	Түүхий эд материал	47,882,676.81	49,977,542.31
35110	Тусгай зорнуулалттай материал	46,947,044.01	49,041,909.51
35130	Эм боох материал	935,632.80	935,632.80
354	Хангамжийн материал	18,048,056.62	17,997,306.62
35410	Бичиг хэргийн материал	1,737,850.00	1,763,600.00
35420	Аж ахуйн материал	14,437,206.62	14,457,206.62
35430	Сэлбэг хэрэгсэл	1,873,000.00	1,776,500.00
35600	Мал амьтад	92,549,000.00	97,314,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	441,603,604.74	566,016,195.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	441,603,604.74	566,016,195.19
392	Биет хөрөнгө	318,143,604.70	343,466,195.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	153,740,217.00	278,491,082.00
39202	Хуримлагдсан элэгдэл	(11,359,891.50)	(31,056,787.69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,900,000.00	135,099,700.00
39204	Хуримлагдсан элэгдэл	(91,703,125.00)	(100,305,490.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,980,587.15	60,554,287.35
39206	Хуримлагдсан элэгдэл	(22,363,595.96)	(29,201,722.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,241,986.13	40,418,881.91
39208	Хуримлагдсан элэгдэл	(10,640,415.21)	(10,533,755.88)
393	Биет бус хөрөнгө	123,460,000.04	222,550,000.08
39301	Програм хангамж	7,000,000.00	7,000,000.00
39302	Хуримлагдсан элэгдэл	(3,539,999.96)	(4,899,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	120,000,000.00	220,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	607,283,338.17	731,305,044.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	607,283,338.17	731,305,044.12
51	Засгийн газрын хувь оролцоо	607,283,338.17	731,305,044.12
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/		100,450,000.00
51101	Өмч: - төрний	809,992,767.15	809,992,767.15
512	Хуримлагдсан үр дүн	(210,735,274.29)	(187,163,568.34)
51210	Өмнөх үеийн үр дүн	(241,309,270.66)	(205,974,312.38)
51220	Тайлант үеийн үр дүн	30,573,996.37	18,810,744.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,025,845.31	8,025,845.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	607,283,338.17	731,305,044.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	399,597,002.25	453,451,888.52
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	67,723,091.25	112,636,629.42
120	Нийтлэг татварын бүс орлого	67,723,091.25	112,636,629.42
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,723,091.25	112,636,629.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй худалдан авсан орлого	64,723,091.25	112,636,629.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,873,911.00	340,815,259.10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,817,000.00	274,957,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,817,000.00	274,957,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,056,911.00	65,857,859.10
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,056,911.00	52,792,401.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,065,458.10
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	369,023,005.88	392,500,344.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,023,005.88	392,500,344.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,867,606.02	380,013,429.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,734,328.14	220,567,340.61
210101	Үндсэн цалин	158,144,223.14	162,800,830.69
210102	Нэмэгдэл	50,198,605.00	38,366,797.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,391,500.00	13,407,180.00
210104	Урамшуулал	-	5,992,532.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,697,100.00	29,824,300.00
210201	Тэтгэврийн даатгал	21,986,800.00	20,921,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,177,600.00	2,225,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,742,000.00	1,780,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	435,600.00	445,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,355,100.00	4,451,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,476,098.00	3,258,214.00
210301	Гэрэл, шахилгаан	1,559,871.00	1,179,133.00
210302	Түлш, халаалт	1,113,573.00	1,452,291.00
210303	Цэвэр, бохир ус	802,654.00	626,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,561,588.25	14,181,531.00
210401	Бичиг хэрэг	1,338,247.25	1,101,750.00
210402	Тээвэр, шатахуун	13,718,721.00	12,036,671.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	909,500.00	861,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	2,181,570.00	181,910.00
210408	Бараа материал ахалсны зардал	8,413,550.00	-
2105	Нормативт зардал	534,395.09	129,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	453,745.09	-
210503	Нормын хувцас, зөөлөн элдэл	80,650.00	129,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,699,720.00	3,152,400.00
210601	Багаж, техник хэрэгсэл	5,653,300.00	3,111,200.00
210604	Урсгал засвар	46,420.00	41,200.00
2107	Томилголт, зочны зардал	1,422,300.00	1,504,100.00
210702	Дотоод албан томилголт	1,422,300.00	1,504,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,142,894.00	70,759,588.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,210,890.00	61,831,288.10
210803	Даатгалын үйлчилгээ	675,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,912.00	121,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	7,200,000.00
210807	Газрын төлбөр	263,092.00	640,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,599,182.54	36,636,265.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,783,100.00	4,957,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	25,816,082.54	31,679,165.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,155,399.86	12,486,915.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,122,000.00	2,131,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,122,000.00	2,131,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,033,399.86	10,355,415.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,033,399.86	10,355,415.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	30,573,996.37	60,951,544.04
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН	-	42,140,800.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	42,140,800.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(42,140,800.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	30,573,996.37	18,810,744.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	334,873,911.00	350,085,429.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	3,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,873,911.00	350,085,429.10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,817,000.00	274,957,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	317,817,000.00	274,957,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,056,911.00	75,128,029.10
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,056,911.00	52,792,401.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,335,628.10
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	334,873,911.00	350,085,429.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,873,911.00	350,085,429.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,718,511.14	337,598,513.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,734,328.14	220,567,340.61
210101	Үндсэн цалин	158,144,223.14	162,800,830.69
210102	Нэмэгдэл	50,198,605.00	38,366,797.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,391,500.00	13,407,180.00
210104	Урамшуулал	-	5,992,532.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,697,100.00	29,824,300.00
210201	Тэтгэврийн даатгал	21,986,800.00	20,921,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,177,600.00	2,225,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,742,000.00	1,780,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	435,600.00	445,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,355,100.00	4,451,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,476,098.00	3,258,214.00
210301	Гэрэл, цахилгаан	1,559,871.00	1,179,133.00
210302	Тулш, халаалт	1,113,573.00	1,452,291.00
210303	Цэвэр, бохир ус	802,654.00	626,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,412,100.00	5,291,500.00
210401	Бичиг хэрэг	1,187,200.00	965,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,315,400.00	3,465,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	909,500.00	861,200.00
2105	Нормативт зардал	465,570.00	197,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	465,570.00	197,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,856,900.00	3,055,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,808,500.00	3,014,700.00
210604	Урсгал засвар	48,400.00	41,200.00
2107	Төмилөлт, зочны зардал	1,422,300.00	1,504,100.00
210702	Дотоод албан төмилөлт	1,422,300.00	1,504,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,354,115.00	72,316,659.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,222,111.00	70,588,359.10
210803	Даатгалын үйлчилгээ	675,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	327,912.00	121,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	-
210807	Газрын төлбөр	263,092.00	640,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,300,000.00	1,582,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,300,000.00	1,582,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,155,399.86	12,486,915.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,122,000.00	2,131,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,122,000.00	2,131,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,033,399.86	10,355,415.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,033,399.86	10,355,415.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	809,992,767.15	8,025,845.31	-210,735,274.29	0.00	607,283,338.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,760,961.91	0.00	4,760,961.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	809,992,767.15	8,025,845.31	-205,974,312.38	0.00	612,044,300.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	100,450,000.00	0.00	0.00	0.00	100,450,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	18,810,744.04	0.00	18,810,744.04
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	910,442,767.15	8,025,845.31	-187,163,568.34	0.00	731,305,044.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	274,957,400.00	273,872,154.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,957,400.00	273,872,154.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	272,825,900.00	271,740,654.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,579,000.00	220,567,340.61
210101	Үндсэн цалин	142,152,100.00	162,800,830.69
210102	Нэмэгдэл	59,171,200.00	38,366,797.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,706,000.00	13,407,180.00
210104	Урамшуулал	5,549,700.00	5,992,532.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,824,300.00	29,824,300.00
210201	Тэтгэврийн даатгал	20,921,100.00	20,921,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,225,800.00	2,225,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,780,600.00	1,780,600.00
210204	Ажил үйлдлийн даатгал	445,200.00	445,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,451,600.00	4,451,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,331,800.00	3,258,214.00
210301	Гэрэл, цахилгаан	1,732,900.00	1,179,133.00
210302	Түлш, халаалт	1,658,200.00	1,452,291.00
210303	Цэвэр, бохир ус	940,700.00	626,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,291,500.00	5,291,500.00
210401	Бичиг хэрэг	965,200.00	965,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,465,100.00	3,465,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	861,200.00	861,200.00
2105	Нормативт зардал	197,900.00	197,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	197,900.00	197,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,055,900.00	3,055,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,014,700.00	3,014,700.00
210604	Урсгал засвар	41,200.00	41,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,504,100.00	1,504,100.00
210702	Дотоод албан томилолт	1,504,100.00	1,504,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,458,800.00	6,458,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,730,500.00	4,730,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	121,800.00	121,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	640,500.00	640,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,582,600.00	1,582,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,582,600.00	1,582,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,131,500.00	2,131,500.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,131,500.00	2,131,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,131,500.00	2,131,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	274,957,400.00	273,872,154.61
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	274,957,400.00	273,872,154.61
122005	Орон нутгийн төсвөөс	274,957,400.00	273,872,154.61
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	22.00	21.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	20.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,857,859.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,857,859.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,857,859.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,857,859.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,857,859.10
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,270,170.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	9,270,170.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,128,029.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,128,029.10
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,792,401.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,335,628.10
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуйн газрын эрхэм зорилго салбарын болон орон нутгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн эдийн засагт хүнс, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд оршдог. Газар нь мал аж ахуй, газар тариалан, хүнсний болон хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, дотоод худалдааны салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлэх, салбарын чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, салбарын статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бодлого болон малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого болон хөрс, ургамал хамгаалал, үр сортын шинэчлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хүнс, хоол үйлдвэрлэл, дотоод худалдааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зорилт дэвшүүлэн ажилладаг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 104 хууль, үүнээс салбарын хэмжээнд 76, нийтлэг мөрддөг 28 хуулийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн захиргааны удирдлага, зохион байгуулалт, мал аж ахуй, газар тариалан, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо, ахуй үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийн чиглэлийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажилладаг.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 52.8 сая төгрөг, ХХААХҮЯ-наас 11.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 11.3 сая төгрөг, нийт 75.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн ажилласан байна.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 65.8 сая төгрөгийг зарцуулж, 9.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааны тайлагналт, ил тод байдлыг сайжруулахтай холбоотой шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 48 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 329.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор харьяа яамнаас төсөвт 5 удаа тодотгол хийж, үр ашиггүй зардал гаргахгүй ажиллахад анхаарч ажиллахыг зөвлөж, цахилгаан эрчим хүч, цэвэр бохир ус хэмнэх, өрөө тасалгааны дулаан алдалтыг багасгах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Байгууллагын авто машины улсын дугаарын дэвсгэрийг бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод өнгө бүхий дугаар авч ашиглаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагын автомашины улсын дугаарыг бусад автомашины улсын дугаараас ялгагдах тод өнгө бүхий дэвсгэртэй улсын дугаараар сольж ашиглах зөвлөмж өгөв.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2023.05.20-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь 2022 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан сар улирлын мэдээ, 6.4-т заасан долоо хоногийн дотор байршуулах 11 ширхэг 22.2 сая төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага бичив.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар маягтын НХМаягт Т-4-ийг бүрэн хөтөлж ажиллах зөвлөмж, цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж олгосонд 1 албан шаардлага, Жолоочийн замын тооцооны хуудсыг бүрэн хөтөлж, спидометрийн заалтыг тэмдэглэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	500.0	1	500.0	100
Зөвлөмж	2	3,700.0	2	3,700.0	100
Нийт дүн	3	4,200.0	3	4,200.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага бичигдээгүй болно

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим сайтад 22.2 сая төгрөгийн 11 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	1	22,209	-	-	1	22,209	-	-
Дүн	1	22,209	-	-	1	22,209	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил								
Автомашин дугаарын дэвсгэрийг бусад автомашины дугаараас ялгагдах тод өнгийн дэвсгэр авч ашиглаагүй	1	0	-	-	-	-	1	0
Дүн	1	0	-	-	-	-	1	0
Нийт дүн	2	22,209			1	22,209	1	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр 5

Дугаар *42 ДА-2023/49/НА-ОТ-7113* Нойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайланд онд шилэн дансны цахим хуусанд 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж ажилласан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор," "6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" гэсэн заалтуудтай нийцэхгүй мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд байршуулж ажиллаж биелэлтийг 2023 оны 5 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбаяр, нягтлан бодогч Б.Золзаяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

М.УХААНБИЛЭГ



011040012